

“ИХ НАЙМ”-ЫН ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ*Х.Мандухай**

Group of eight, G8 хэмээх “Их найм”-ын бүлэг нь аж үйлдвэржсэн хөгжингүй орнууд болох АНУ, Их Британи, ОХУ, Франц, Япон, Герман, Канад, Италийн удирдагчдын албан ёсны бус чуулга уулзалт /форум/ юм. Европын Хамтын Нийгэмлэгийн комисс, сүүлийн үед НҮБ-ын оролцоотой болдог тус форумын хүрээнд олон улсын тулгамдсан асуудлаар баримтлах байр сууриа зохицуулах явдлаа хэрэгжүүлдэг байна. Одоо БНХАУ, Энэтхэг, Бразил, Мексик, БН Өмнөд Африкийн Улс, Испани зэрэг орны төлөөлөгчид оролцдог болсон.

“Найм”-ын буюу урьд нь “Долоо”-гийн бүлгийн түүх нь 1975 оноос эхтэй юм. Энэ онд Францын Ерөнхийлөгч В.Жаскар Д’Эстэний санаачлагаар Рамбуйе хотноо эхлээд “Зургаагийн бүлэг” байснаа Канад улс элсэн орсноор “Долоогийн бүлэг” болон хуралдав. Анхны үедээ макро эдийн засгийн сэдэв болон дэлхийн эдийн засгийн хөгжлийн глобал чиглэлүүдийг үндсэндээ хэлэлцдэг байжээ. Уг форумын шүүн хэлэлцдэг сэдвийн дотор хожим нь улс төрийн тулгарсан асуудлуудыг багтаан оруулах болжээ. Энэ дэг журам нь “Наймынхан”-ы бүрэлдсэн үе болох 1994 оноос бүрмөсөн хэвшсэн юм.

“Их найм” нь олон улсын байгууллагын статустай биш учраас олон улсын гэрээн дээр үндэслэсэн өөрийн дүрэм болон нарийн бичгийн дарга нарын газар албан ёсоор байхгүй. “Наймынхны” гаргасан шийдвэр нь ч заавал хүчин төгөлдөр байх албагүй юм. Чухамдаа энэ шийдэл нь гишүүн талуудыг тулгамдсан асуудлаар уялдуулж зохицуулсан чиг шугамыг дагаж мөрдөх, эсвэл гишүүн бус оролцогч нарт аливаа асуудлуудыг шийдвэрлэхэд тодорхой байр суурьтай байхыг зөвлөсөн зөвлөмжийн чанартай юм.

“Наймын бүлэг” өөрийн үйл ажиллагааныхаа тогтсон дэг журамтай. Дээд хэмжээний жил тутмын ээлжит уулзалт буюу дээд хэмжээний саммитыг зохион байгуулж байгаа орон нь тухайн жилийн турш “Наймын бүлэг”-ийн даргын үүрэг гүйцэтгэдэг. Тухайн улс нь саммитаас гадна, яамдын болон ажлын хэсгүүдийн уулзалтыг зохион байгуулж, “Наймынханы” үйл ажиллагааг жилийн турш зохицуулах үүрэг хүлээдэг. Жилийн хугацаа дуусмагц даргалах үүргээ ротац буюу ээлжлэлийн журмаар дараагийн улсад шилжүүлэн өгдөг байна. Ээлжлэл нь Франц улсаас эхлэж, цааш нь өнөөг хүртэл АНУ, Их Британи, ХБНГУ, Япон, Итали, Канад, ОХУ, Япон улс гэхчлэн дэс дараалдаг. Жил бүрийн үйл ажиллагааны гол арга хэмжээ нь саммит бөгөөд үүнийг бэлтгэж зохион явуулахад чиглэдэг юм.

* Х.Мандухай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Төр засгийн тэргүүн нарын яриа хэлцэл нь хязгаарлагдмал хүрээнд албан ёсны хийгээд итгэлцлийн нөхцөлд өнгөрдөг заншилтай бөгөөд тухайн сэдвээр хэлэлцсэн нарийн зүйлийн агуулгыг нийтэд илээр гаргаж мэдээлдэггүй нууцлаг зарчимтай. Үүний хамт “Наймынхан” үйл ажиллагааныхаа нээлттэй ил тод байдлыг хангах, өргөн олон нийт болон олон улсын төрийн бус байгууллагуудтай хэлхээ холбоо бэхжүүлэхийг хичээн эрмэлзэдэг.

“Наймын бүлэг” зөвшилцөлийн зарчим баримталдаг. Саммит болон сайд нарын түвшинд болсон уулзалтын төгсгөлд хамтарсан баримт бичиг гаргаж, энэ тухайгаа хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан олноо сонордуулдаг. Олон улсын нэн чухал үйл явдлуудыг тохиолдуулан нүүр тулсан уулзалтуудыг зохион байгуулахгүйгээр төрийн тэргүүн, сайд нар тусгайлан мэдэгдэл гаргах явдал хэвшиж байна. “Наймын бүлэг”-ийн харилцан ажиллагаа нь зохион байгуулалтын олон түвшинт, уян хатан бүтцийн тусламжтайгаар хэрэгжидэг бөгөөд тэр нь тухайн арга ажиллагааны нилээд үр ашигтай байдлыг хангаж өгдөг байна.

Саммит бэлтгэх явцад гадаад хэргийн сайд нарын уулзалтыг НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы өмнөхөн зохион байгуулж, шаардлагатай бол ээлжит бус уулзалт ч зохион байгуулдаг. Сангийн сайд нарын саммит болохын өмнө ОУВС болон Дэлхийн сэргээн босголт, хөгжлийн банк /International Bank for Reconstruction and Development/-ны удирдах газруудын чуулгантай нягт уялдуулан зохион байгуулдаг уулзалтууд улс төрийн чухал үүрэгтэй. Саммитад бэлтгэх ажлын хүрээнд байгаль орчин, эрчим хүч, хөдөлмөр ба нийгмийн хөгжил, эрүүлийг хамгаалах, боловсрол, дотоодын асуудал, хууль зүй, шинжлэх ухаан, технологийн болон бусад асуудлаар сайд нарын уулзалтуудыг урьдчилан тохиролцсон ёсоор зохион байгуулдаг.

Бэлтгэл бүхий л ажлыг төр засгийн тэргүүний бүрэн эрхт төлөөлөгч буюу шерпа /sherpa/ удирдаж зохицуулна. Тус үгийн үүслийн тухайд тодруулан тайлбарлавал, маш сонирхолтой түүхтэй юм. Төвд гаралтай шерпа үндэстэн нь Балба, Энэтхэгт оршин суудаг бөгөөд англи галиг нь sherpa буюу shar “дорнод”, ра “хүмүүс” гэсэн утгатай. Харин тэд өөрснийгөө шаркхомбо гэж нэрлэдэг аж. Шерпа нарын ярьдаг кангпо хэл нь төвд-бирм хэлний аймагт хамаардаг. Балбын шерпанууд төмс, овъёос тарьж, сарлаг тэжээдэг бол, Энэтхэгт амьдардаг шерпанууд наймаа эрхэлж, Гималайн ууланд авирах онцгой авьяас чадвартай.

Шерпа гэдэг үгийн англи хэлэнд нэвтэрсэн утга нь “дээд хэмжээний уулзалтыг бэлтгэх” гэсэн утга илэрхийлдэг. Үүнд олон улсын экспедициуд Гималайн оргилд хүрэхэд шерпа үндэстний дэлхийд хосгүй авьяас чадварыг үнэлсэн түүхтэй юм. Эхлээд энэ нэр томъёо албан бус журмаар Европын Холбооны Засгийн газар хоорондын хурал /Intergovernmental

Conference, IGC/-д бэлтгэдэг гишүүн-орнуудын төлөөлөгчдийг нэрлэдэг байжээ. Харин сүүлд улс орнуудын тэргүүнүүдийн оролцоотой дээд хэмжээний байнгын уулзалтыг зохион байгуулдаг бүрэн эрхт төлөөлөгчдийн нэр болон хувирсан. Жишээ нь, Францад G8-ийн шерпа болон Европын комиссийн шерпа гэж тус тус байдаг аж.

Шерпа нь тухайн улсын ээлжит даргалах үед саммитыг зохион байгуулах ажлыг бүрэн хариуцаж, “Их найм”-ын гишүүн-орнуудын тэргүүнүүдтэй холбоо барьж, саммитын хэлэлцэх асуудал, хэлэлцээрийн төслийг бэлтгэдэг чухал үүрэгтэй. Энэхүү чиглэлийн үйл ажиллагаа нь харилцан мэдээлэл солилцож, итгэлцэл зөвшилцлийг бий болгоход чиглэнэ. Шерпа-нуудын уулзалт жилд 4-5 удаа болж, төрийн тэргүүнүүдийн уулзалтан дээр зөвхөн шерпа-нууд оролцох онцгой эрхтэй.

Шерпа нь улс төрийн су-шерпа, гадаад харилцааны су-шерпа, санхүүгийн су-шерпа-нуудаас бүрдсэн үндэсний баг удирддаг. Шерпа нь “Их найм”-ын байнгын ажлын талаар мэдээлэл болон зөвлөлгөө, итгэлцлийн журам дээр тогтсон байнгын механизмтай.

Ээлжит саммит зохион байгуулах бэлтгэл үйл ажиллагааны хүрээнд шерпа, су-шерпын түвшинд хэд хэдэн зөвлөгөөн болдог. Бэлтгэх ажлын дүнд саммитын тов гаргаж, батлах баримт бичгүүдийн төсөл боловсруулан хэлэлцэж, зохион байгуулалтын бусад асуудлуудыг авч хэлэлцдэг зарчимтай. Улс төрийн су-шерпа-гийн уулзалт нь саммит болон сайд нарын уулзалтын бэлтгэх ажил гэж үздэг бөгөөд мөн гишүүн-орнуудын тэргүүнүүдийн улс төрийн асуудлуудыг боловсруулдаг. Үүнд бэлтгэх ажлын явцад утас болон захидлаар харилцан бүх түвшинд санал солилцдог. Зарим тодорхой чиглэлээр тусгай, ажлын болон шинжээчдийн баг гаргаж ажилуулдаг. Эдгээр баг нь гишүүн-орнуудын тэргүүн, сайдын шийдвэрээр урт хугацааны чанартай асуудлуудыг шийдэх буюу ээлжит саммитыг бэлтгэх ажлыг гүйцэтгэдэг. Тухайн чиглэлээс хамааран үүнийг улс төрийн су-шерпа буюу шерпа удирддаг. Мөн сайд нарын хэмжээний уулзалтын бэлтгэх ажлын хүрээнд “Их найм”-ын үйл ажиллагааны тодорхой асуудлуудаар шинжээчдийн уулзалт, семинар зохион байгуулдаг /хөгжлийн асуудлууд, эрүүл мэнд, байгаль орчины хамгаалал, экспортын зээлийн, хүнсний аюулгүй байдал г.м/.

Орчин үеийн олон улсын харилцаанд “Их найм” нь томоохон үүрэг гүйцэтгэж, ОУВС, ДХБ зэрэг байгууллагуудтай зэрэгцэж байна. 1970-аад онд дэлхийн эдийн засагт болсон хямралын үр дүнд байгуулагдсан шалтгаан нь “Их найм”-ын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг өндөр үнэлж байгаа юм. Үүнд:

- Бреттон-Вудын санхүүгийн системийн хямрал болон ОУВС, Дэлхийн сэргээн босголт, хөгжлийн банк /International Bank for

Reconstruction and Development/-ны зүгээс дэлхийн валютын системийг өөрчлөх арга хэмжээ авч чадаагүй юм.

- 1972 онд эхэлсэн Европын Холбооны анхны тэлэлт бөгөөд түүний Барууны эдийн засагт үзүүлсэн нөлөө.

- 1973 оны 10-р сарын газрын тосны анхны олон улсын хямрал нь Барууны орнууд болон ОПЕК-ийн хооронд зөрчилд хүргэсэн.

- Газрын тосны хямралын үр дүнд 1974 онд эхэлсэн эдийн засгийн хямрал нь инфляци, ажилгүйдлийг бий болгов.

“Их найм”-ын үйл ажиллагааг авч үзвэл, дараахь үе шаттай:

1975-1980 - гишүүн-орнуудын эдийн засгийн бодлогыг хөгжүүлэх эрчимтэй бодлого баримтлаж байсан.

1981-1988 - гадаад бодлогын эдийн засгийн бус асуудалд анхаарал хандуулж эхэлсэн.

1989-1994 - “хүйтэн дайны” дараа Төв болон Дорнод Европын орнууд, ЗХУ-ын өөрчлөн байгуулалт, худалдаа болон өрийн асуудал, мөн байгаль орчин, хар тамхи, мөнгө хууль бусаар угаах зэрэг асуудал хэлэлцэж эхэлсэн.

1995 оны Галифакс-т болсон саммитын дараа орчин үеийн үе шат эхэлсэн гэж үздэг. Тус байгууллагад ОХУ элсэн оров. Олон улсын институтын бүтцийн өөрчлөлт болон “дэлхийн шинэ дэг журам” тогтсон.

Тус байгууллага үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн 1975 оноос хойш өнөөг хүртэл нийтдээ 34 удаа саммит зохион байгуулав. 2004 онд АНУ даргалж, Си-Айлэнд арал дээр 30-р саммитыг зохион байгуулж, дэлхийн эдийн засаг, аюулгүй байдал, Ойрхи Дорнод, Иракийн байдал, Орос, Японы харилцаа, мөн үг хэлэх эрх чөлөөний тухай сэдвээр хэлэлцэв. 2005 онд Их Британи даргалж, мөн оны 6-р сарын 6-8-нд Шотландын Глениглс хотноо “Их найм”-ын 31-р саммит болж, дэлхийн байгалийн уур амьсгал, Африкийн ядуу орнуудад тусламж үзүүлэх тухай ярилцсан. 2006 онд ОХУ даргалж, Санкт-Петербург хотноо 32-р саммит дээр эрчим хүчний аюулгүй байдал, хүн амын хөдөлгөөн, боловсрол, терроризмтэй тэмцэх хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөтгөх асуудал болон Ойрхи Дорнодын талаар авч хэлэлцэв. 2007 онд Хайлигедамм хотноо 33-р ээлжит саммитыг Герман зохион байгуулж, мөн дэлхийн байгалийн уур амьсгал, Африкийн ядуу орнуудад тусламж үзүүлэх тухай сэдвээр хэлэлцсэн. 2008 онд Япон улс даргалж, Тояко хотноо болж өнгөрсөн 34-р саммит дээр хүнсний үнийг бууруулах, мөнгөний инфляцитай тэмцэх тухай асуудал хөндөгджээ.